



mobicom

МОБИКОМ
КОРПОРАЦИ ХХК

14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж - 28, МПМ Цогцолбор, Утас: 75759944,
Факс: +976-11-310411, <http://www.mobicom.mn>

2026 .08. 05

№

1/1922

танай

-ны №

-т

Г

Г

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Мобиком корпораци ХХК нь өөрийн сүлжээнд харилцан холболт хийхээр хүсэлт гаргаж буй үйлчилгээ эрхлэгчидтэй хийх гэрээний нөхцөлийг шинэчлэх зорилгоор Харилцаа холбооны зохицуулах хорооны асуудал хариуцсан албан тушаалтнуудтай удаа дараа уулзалт зохион байгуулж, гэрээнд тусгах зүйл заалтын талаар тайлбар мэдээллийг өгч ажилласан билээ.

Тус хорооны зүгээс бидний тавьж буй дээрх асуудлыг хянаж, зөвлөмж өгч ажилласан үндсэн дээр талууд 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн уулзалтаар гэрээний нэмэлт нөхцөл, зүйл заалтыг эцэслэсэн болно.

Тиймээс “Харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл”-ийг 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдөр шинэчлэн баталж, өөрийн цахим хуудсанд байршуулсан байх тул энэ талаарх мэдээллийг та бүхэнд хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөлийг хавсралтаар хүргүүлэв.

Хүндэтгэсэн,


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ОЧИ ЯСҮХИРО

0003780



INTEGRATED MANAGEMENT SYSTEM



2518
20 26.08.07
13 20

БАТЛАВ:



ЯСҮХИРО ОЧИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК-ИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ
ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ (RIO1¹)**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.3² дахь хэсэгт зааснаар харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (цаашид “нөхцөл” гэх) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, цахим хуудсандаа байршуулах үүрэгтэй.
- 1.2 Энэхүү харилцан холболт хийх гэрээний нөхцөлийн зорилго нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч бусад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд харилцан холбогдох үйл ажиллагааг нээлттэй болгох, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн харилцан холболт хийх эрхийг баталгаажуулах, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн техник технологийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх з эргээр энэ нөхцөлийн 1.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд оршино.
- 1.3 Энэхүү нөхцөл нь Мобиком Корпораци ХХК (цаашид “Мобиком” гэх) болон тусгай зөвшөөрөл бүхий сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлт гаргагч (цаашид “Хүсэлт гаргагч” гэх) нарын (хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох, зааглах цэгийн байршил, гэрээ байгуулах, сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр, орлого хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.4 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үйлчлэгчтэй сүлжээнд харилцан холболт хийх гэрээ байгуулахдаа хууль, журам болон энэхүү нөхцөлд заасан хэм хэмжээг мөрдөнө.

ХОЁР. НЭР ТОМЪЁО

- 2.1 “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөл” гэж “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.3 дахь хэсэгт заасан мэдээллийг агуулсан баримт бичгийг ойлгоно.
- 2.2 Телефон ярианы үйлчилгээ гэдэгт “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Телефон ярианы үйлчилгээнд)-ын 1.3³-д заасан суурин болон үүрэн холбооны бүх төрлийн телефон ярианы үйлчилгээг ойлгоно.
- 2.3 Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч гэдэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.1-15.16.3, 15.16.5-15.16.7⁴-д заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг ойлгоно.

¹ Reference Interconnection offer, Энэхүү баримт бичгийн 2.1 дэх хэсгийг харна уу.

² Сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (RIO) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулж баталж өөрийн вэб хуудсанд байршуулах бөгөөд дараах мэдээллийг заавал тусгасан байна. Үүнд:

2.3.1. Тухайн сүлжээнд харилцан холболт хийх технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага;

2.3.2. Зааглах цэгийн байршил

2.3.3. Сүлжээнд харилцан холболт хийх төлбөр тооцооны мэдээлэл;

2.3.4. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл;

2.3.5. Гэрээний загвар

³ Телефон ярианы үйлчилгээ гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас бусад улс орнуудад цахилгаан холбооны сүлжээ ашиглан Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос хуваарилсан дугаарыг ашиглан хэрэглэгчид үзүүлж буй суурин болон үүрэн холбооны бүх төрлийн телефон ярианы үйлчилгээг ойлгоно.

- 2.4 Зааглах цэг гэж Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7⁵-д зааснаар үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг ойлгоно.

ГУРАВ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 3.1 Мобиком нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох Хүсэлт гаргагчдад ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх зарчмыг баримтална.
- 3.2 Мобиком нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох нээлттэй сүлжээний стандартыг хангах зарчмыг баримтална.
- 3.3 Талууд нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, орлого хуваарилах зарчим, төлбөрийн хэмжээг тогтоохдоо аливаа бизнесийн алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй.
- 3.4 Сүлжээ хооронд харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх нөхцөлд *"Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам"*-ын 2.1.1 дэх заалтыг баримтална.

ДӨРӨВ. ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТ, ГОРИМ, НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 4.1 Хүсэлт гаргагчийн техник, төхөөрөмж нь Үндэсний болон Олон улсын стандартын шаардлагыг хангасан Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар баталгаажуулагдсан, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх бусад сүлжээтэй харилцан холбогдох техникийн нөхцөлийг бүрэн хангасан байна.
- 4.2 Хүсэлт гаргагч нь харилцаа холбооны үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор сүлжээний удирдлага, хяналтын нэгдсэн системтэй байна. Хяналтын нэгдсэн системийн мэдээллийг 6 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгална.
- 4.3 Хүсэлт гаргагч нь өөрийн үйлчилгээний чанар, стандарт болон норматив шаардлагыг ханган ажиллах зорилгын хүрээнд техник, тоног төхөөрөмжид байнгын хэмжилт, тогтмол хяналт хийх хэмжүүрийн багаж, хэрэгсэл эсхүл програм хангамжаар хангагдсан байна.
- 4.4 Хүсэлт гаргагч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхтэй холбоотой техник, тоног төхөөрөмжийн угсралт болон кабель шугамын суурилуулалтыг хийж гүйцэтгэхдээ энэ талаар батлагдан гарсан Үндэсний стандарт, норматив баримт бичгийг мөрдөж ажиллах ба хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээнд ашиглагдахаар байгуулсан сүлжээний найдвартай ажиллагаа, инженер техникийн ажилтны аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хангасан байна.
- 4.5 Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан холболтын байгууламжтай байна. Үүнд:
- 4.5.1 дотоод болон олон улсын ярианы хувьд:
 - 4.5.1.1 CCS7 дохиолол эсвэл SIP протоколуудыг дэмждэг байх;
 - 4.5.1.2 AMR, PCMU, PCMA кодыг дэмжих, кодек хоорондын хувиргалт, шилжилт хийдэг байх;
 - 4.5.1.3 станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь 10^{-11} байх;
 - 4.5.1.4 ярианы төлбөрийг секундын нарийвчлалтай тооцох боломжтой байх;
 - 4.5.2 дотоод болон олон улсын мессежний хувьд:
 - 4.5.2.1 SMPP 3.4 протоколыг дэмждэг байх.
- 4.6 Хүсэлт гаргагч нь ярианы үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дээрх стандартыг хангасан холболтын байгууламж (soft switch, gateway, router), төлбөр тооцооны систем (billing system), зай тэжээлийн төхөөрөмж болон тэдгээрийн хяналтын систем (network management system)-ийг ашиглана.
- 4.7 Хүсэлт гаргагч нь хуурамч дуудлага, дугаараа өөрчилж залгасан дуудлага, спам мессеж, дуудлагыг (spoof call, sim box detection, long call alerting, traffic volume assurance, telemarketing, spam messaging) илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх техник, тоног төхөөрөмжийн боломжийг бүрдүүлсэн байнгын хяналт хийж ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.

⁴Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл гэдэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.1-15.16.3, 15.16.5-15.16.7-д заасан тусгай зөвшөөрөл тус тус хамаарна.

⁵ 3.1.7. "зааглах цэг" гэж үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг;

- 4.8 Хүсэлт гаргагч нь орох дуудлагын хувьд ОУЦХБ-ын Е.164-ийн дагуу дуудлагыг эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулдаг (CLI-Calling Line Identification) байна.
- 4.9 Хүсэлт гаргагч нь өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.
- 4.10 Хүсэлт гаргагчаас ирүүлсэн харилцан холболт хийх хүсэлт дээр хийгдсэн ачааллын таамаглал нь Мобикомын тухайн үеийн багтаамжаас давах тохиолдолд харилцан холболтыг хийж гүйцэтгэх хугацааг, нөөц бэлэн болох хугацаатай уялдуулж Хүсэлт гаргагчтай харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 4.11 Хэрэв Хүсэлт гаргагч нь энэ нөхцөлийн 4 дүгээр зүйлд дурдсан техникийн нөхцөл шаардлагыг хангаагүй бол Мобиком нь харилцан холболт хийхээс татгалзаж болно.
- 4.12 Сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх горимд нөлөөлөхүйц технологийн шинэчлэлийг аль нэг тал нь санаачлан хийх бол 3 сараас доошгүй хугацааны өмнө өөрчлөлт хийх талаарх мэдээлэл, үндэслэл, шаардагдах техникийн нөхцөлийг нөгөө талд мэдэгдэн тохиролцох ба энэ талаар Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

ТАВ. ЗААГЛАХ ЦЭГ ТОГТООХ НӨХЦӨЛ

- 5.1 Мобиком нь өөрийн сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг болон сүлжээнд холбогдох зааглах цэгийн байршил сүлжээний болон дамжуулах төхөөрөмжийг энэхүү нөхцөлийн Хавсралт 1-д заасан байх ба зааглах цэгийн байршлыг Зохицуулах хороо эцэслэн баталгаажуулна.
- 5.2 Зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн наймдугаар зүйлийн гэрээний загвар хэсэгт энэхүү нөхцөлийн 5.1 дэх хэсгийн дагуу Хүсэлт гаргагчтай байгуулах *Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ*-нд нарийвчлан, тодорхой оруулна.
- 5.3 Хүсэлт гаргагч нь Харилцаа холбооны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1⁶ дэх хэсэгт заасны дагуу харилцаа холбооны үйлчлэгчийн сүлжээнд харилцан холболт хийх зааглах цэг хүртэл шаардагдах хөрөнгө оруулалтыг хариуцна.
- 5.4 Талууд зөвхөн Зохицуулах хорооноос тогтоосон зааглах цэгт сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох үйлчилгээг үзүүлнэ.
- 5.5 Хүсэлт гаргагч нь зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 5.1 дэх хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоох хүсэлт ирүүлсэн бол Мобиком нь хүсэлтийн дагуу техникийн нөхцөлийн боломж байгаа эсэхийг тодорхойлж, дүгнэлтийг Зохицуулах хороонд албан бичгээр хүргүүлж, шийдвэрлүүлнэ. Харин Мобиком нь зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 5.1 дэх хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоох хүсэлттэй бол Зохицуулах хороонд үндэслэл, техникийн нөхцөлийн боломжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлж тухай бүр шийдвэрлүүлнэ.
- 5.6 Талууд сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгээр тусгаарлан холбогдох хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1 Талууд сүлжээ хоорондын харилцан холболтын болон сүлжээнд холбогдох зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцна.
- 6.2 Талууд үйлчилгээний чанарын шаардлагыг хангах үүднээс тус тусын хариуцаж буй зааглах цэг хүртэлх сүлжээ, дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд энэхүү нөхцөлийн Хавсралт 2-д заасан гэрээний загварт дангаар эсхүл харилцан тусгай нөхцөл тогтоож болно.
- 6.3 Сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд урьдчилж харилцан тохиролцож гэрээнд тусгах ба үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

⁶ 22.1. Тусгай хэрэглээний холбооны сүлжээ эзэмшигч, дотоодын хэрэглээний сүлжээ бүхий болон шинээр сүлжээ байгуулах этгээд бусдын өмчлөлийн сүлжээнд холболт хийхдээ сүлжээ хоорондын зааглах цэгт тавигдах нэмэгдэл шугам, тоног төхөөрөмжийг хариуцна.

ДОЛОО. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТӨЛБӨР ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

- 7.1 Мобиком нь сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний төлбөрийг журмын 8 дугаар зүйлд заасны дагуу тогтоож, Хавсралт 4-д нарийвчлан тусгана.
- 7.2 Мобиком нь сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний өртгийг тооцохдоо Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэгт заасан харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал, ОУЦХБ-аас гаргасан зөвлөмж, аргачлал загвар, нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэнэ.
- 7.3 Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалгаалан өртгөө нөхсөн байна.
- 7.4 Зохицуулах хорооноос харилцаа холбооны төлбөрт зохицуулалт хийсэн тохиолдолд Талууд гэрээнд тусган мөрдөж ажиллана.

НАЙМ. ГЭРЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ

- 8.1 Хүсэлт гаргагч нь сүлжээнд харилцан холболт хийх хүсэлтээ журмын 3.17⁷ дэх хэсэгт заасан хэлбэрээр гаргах бөгөөд Мобиком нь уг хэлбэрээс бусад хэлбэрээр гаргасан аливаа хүсэлтийг шийдвэрлэхгүй.
- 8.2 Хүсэлт гаргагч нь сүлжээнд харилцан холболт хийх хүсэлтдээ дараах мэдээллийг заавал тусгана.
Үүнд:
 - 8.2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн байршил;
 - 8.2.2 Холболт хийх гэж буй төхөөрөмжийн талаарх мэдээлэл;
 - 8.2.3 Тухайн сүлжээнд харилцан холболт хийх технологийн стандарт, горим;
 - 8.2.4 Энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйлд тусгасан гэрээний нөхцөлийг хангах талаар бусад мэдээлэл зэрэг болно.
- 8.3 Мобиком нь техникийн нөхцөл олгох боломжийг судлах зорилгоор энэхүү нөхцөлийн 8.2 дахь хэсэгт зааснаас гадна байгууллагын нууцад хамраахгүй нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 8.4 Мобиком нь энэхүү нөхцөлийн 8.1 дэх хэсэгт заасан хэлбэрээс өөр хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй талаар мэдэгдлийг бичгээр мэдэгдэнэ.
- 8.5 Мобиком нь Хүсэлт гаргагчаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөр шүүж, түрүүлж ирснийг нь эхэнд шийдвэрлэх зарчим баримтална.
- 8.6 Мобиком нь энэхүү нөхцөлийн 8.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авч энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйл сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагад нийцжээ байгаа эсэхийг судалж, журмын 3.2⁸ дахь хэсэгт заасан хугацаанд шахим шуудангаар хариу мэдэгдэнэ. Энэ мэдэгдлийг техникийн нөхцөл гэж ойлгоно.
- 8.7 Хүсэлт гаргагч талд техникийн нөхцөл гаргах боломжгүй болсон тохиолдолд журмын 3.3⁹ дахь хэсэгт заасны дагуу хариу хүргүүлэх бөгөөд уг хариу тайлбартаа техникийн нөхцөл олгох боломжгүй үндэслэлийг тодорхой дурдана.
- 8.8 Хүсэлт гаргагчийн тусгай зөвшөөрөл хуульд заасан үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд Мобикомоос олгогдсон техникийн нөхцөл хүчингүй болно.

ЕС. ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

- 9.1 Мобиком нь Харилцаа холбооны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1¹⁰ дэх хэсэгт зааснаар Хүсэлт гаргагчийг өөрийн сүлжээндээ холбохдоо гэрээ байгуулна.

⁷ Харилцаа холбооны үйлчилгээгээр үйлчлэгч нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг харилцаа холбооны үйлчилгээнд бичгээр гаргана.

⁸ Харилцаа холбооны үйлчлэгч нь уг хүсэлтийг хүлээн авч өөрийн сүлжээнд техникийн боломж, гэрээний нөхцөлийг хангаж буй эсэхийг нягталж, өөрийн сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх боломжтой эсэх талаар судалж, ажлын 10 хоногийн дотор хариуг хүсэлт гаргасан талд бичгээр мэдэгдэнэ.

⁹ Харилцаа холбооны үйлчлэгч нь техникийн нөхцөл гаргах боломжгүй бол хүсэлт гаргагч талд тухайн нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болох хугацааг тодорхой дурдсан холбогдох талаарыг хүргүүлэх ба хүнийг Зохицуулах хороонд заавал хүргүүлнэ.

- 9.2 Энэхүү нөхцөлийн 9.1 дэх хэсэгт заасан гэрээг сүлжээнд харилцан холболт хийх болон сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаар байгуулах ба сүлжээний ашиглалт, үйлчилгээг зохицуулахаар тусдаа гэрээ байгуулахыг хориглоно.
- 9.3 Энэхүү нөхцөлийн Хавсралт 2 дахь Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний төсөл нь холбогдох хууль тогтоомж, Зохицуулах хорооноос баталсан шийдвэр, зохицуулалт, нөхцөл шаардлага, журамтай нийцүүлэн боловсруулагдсан болно.
- 9.4 Сүлжээнд холбогдох харилцан холболтын гэрээний төслийг боловсруулахдаа энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйлд заасан сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагыг салшгүй хэсэг болгоно.
- 9.5 Энэхүү нөхцөлийн 9.4 дэх хэсэгт заасан гэрээний салшгүй хэсэгт сүлжээнд харилцан холболт хийж буй Хүсэлт гаргагчийн хүсэлтээр хууль болон Зохицуулах хорооноос баталсан журам, нөхцөл шаардлага, шийдвэрээр хязгаарласан асуудлаас бусад асуудлаар харилцан тохиролцон өөрчлөлт оруулах боломжтой байна. Бусад тохиолдолд энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйлд зааснаас өөрөөр гэрээнд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 9.6 Сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг хүлээн авах, холболт гүйцэтгэх, гэрээ байгуулах үйл явц нь энэхүү нөхцөлийн Хавсралт 3-т заасан дарааллын дагуу хийгдэнэ.
- 9.7 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор уг гэрээ болон түүний хавсралт, холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хороонд бүртгүүлэх ба уг гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт бүрийг тухай бүр бүртгүүлнэ.
- 9.8 Хүсэлт гаргагч нь гэрээг байгуулахаас өмнө Зохицуулах хороонд хандаж, гэрээний төслийг хянуулах болон холбогдох заавар зөвлөмжийг авч болно.
- 9.9 Хүсэлт гаргагчид олгогдсон техникийн нөхцөл энэхүү нөхцөлийн 8.8 дахь хэсэгт зааснаар хүчингүй болсон тохиолдолд сүлжээний харилцан холболтыг салгах арга хэмжээ авч, Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэх бөгөөд Сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээндээ уг нөхцөлийг хэрэгжүүлэх заалтыг заавал тусгана.
- 9.10 Талууд сүлжээний ашиглалт, үйлчилгээг журмын 7.2¹¹ дахь хэсэгт зааснаас өөрөөр хариуцах тохиолдолд гэрээндээ энэ талаар тодорхой тусгана.
- 9.11 Журмын 7.3¹² дахь хэсэгт заасан сүлжээнд харилцан холболт хийх түүнтэй холбоотой аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд тохиролцон гэрээндээ тусгана.

АРАВ. ГОМДОЛ ГАРГАХ

- 10.1 Энэхүү нөхцөлтэй холбоотой аливаа маргаантай асуудлаар журмын 10.1 дэх хэсэгт заасны дагуу Зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлэх боломжтой.

– о О о –

¹⁰ Үйлчлэгч, хэрэглэгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг Иргэний хуульд заасны дагуу гэрээгээр зохицуулна.

¹¹ Талууд сүлжээ хооронд харилцан холболтын зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцна.

¹² Харилцан холболт хийхтэй холбоотой аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд урьдчилж харилцан тохиролцон тогтоох ба үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.


ЗААГЛАХ ЦЭГ, ХОЛБОЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Мобиком
Холболтын байгууламжийн төрөл, марк	Huawei, Msoft3000 Huawei, UMG8900 Huawei, SBC SE2900
Дамжуулах /нягтруулах төхөөрөмж/ байгууламжийн төрөл, марк	ZXCTN9000 ZXCTN6150
Холбох шугамын төрөл, марк, багтаамж	ISUP, SIP
Интерфейсийн төрөл	E1, Optic fiber, Ethernet

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Зааглах цэг	Байршил
Зааглах цэг 1-ийн байршил	Мобикомын техникийн төв байр, 1-р давхар 106 тоот
Зааглах цэг 1-ийн тоног төхөөрөмж	ZXCTN9000
Зааглах цэг 2-ын байршил	Мэдээлэл Холбооны сүлжээ ТӨХХК-ийн Төв байрын 2 давхар Техникийн өрөө
Зааглах цэг 2-ын тоног төхөөрөмж	ZXCTN6150



*Мобиком Корпораци ХХК-ийн Харилцан холболт
хийх гэрээний ерөнхий нөхцөл, Хавсралт 2*

СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН
ХОЛБОЛТЫН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ

Д/д	Үйл ажиллагаа	Баримтын нэр, хийгдэх хугацаа
1.	Хүсэлт гаргагч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтээ энэхүү нөхцөлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу бичгээр Мобикомд гаргана.	
2.	Хүсэлт гаргагч нь дараах баримтуудыг энэхүү нөхцөлийн 8.2 дахь хэсэгт заасан агуулга бүхий албан тоотын хамт ирүүлнэ.Үүнд: 1. Компанийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. ХХЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар 3. ХХЗХ-той байгуулсан дугаарлалтын гэрээ, холбогдох шийдвэр 4. Холболтын байгууламжийн төрөл, холболтын санал, хамтран ажиллах техникийн болон гэрээ хариуцсан ажилтнуудын утасны дугаар, имэйл хаяг	
3.	Мобиком нь хүлээж авсан баримтын иж бүрдэл бүрэн эсэх, хүчинтэй хугацаа зэргийг хянаж, шалгах, баримт бичгийн иж бүрдэл дутуу, холбогдох мэдээлэл дутуу ирсэн үед энэ талаар Хүсэлт гаргагч руу утсаар эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.	Хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 5 хоног
4.	Энэхүү нөхцөлд дурдагдсан шаардлагыг бүрэн хангасан бол харилцан холболт хийх техникийн боломжийг судалж техникийн нөхцөлийг гаргаж Хүсэлт гаргагч руу цахим шуудангаар илгээнэ.	Ажлын 10 хоног
5.	Сүлжээ хооронд харилцан холболтын гэрээний төслийг Мобиком талаас бэлтгэн Хүсэлт гаргагчийн ирүүлсэн имэйл хаяг руу илгээнэ.	Техникийн нөхцөл гарснаас хойш ажлын 5 хоног
6.	Гэрээний нөхцөлийг Хүсэлт гаргагчтай эцэслэн тохирно.	Гэрээний төсөл илгээснээс хойш хуанлийн 30 хоног
7.	Гэрээг 3 эх хувь үйлдэж батлах ба тал тус бүр нэгийг, үлдэх нэг хувийг Зохицуулах хороо руу харилцан тохирч хүргүүлнэ.	Гэрээ батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор
8.	Гэрээ батлагдаж, техникийн нөхцөлийг тохирсоны дараа дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: 8.1 Харилцан холболтыг хийж гүйцэтгэх; 8.2 Холбогдох тестийг талууд хамтран хийж CDR, тариф зөв эсэхийг шалгаж баталгаажуулах; 8.3 Тестийн үр дүнг протокол үйлдэж баталгаажуулж, тус бүрийн гэрээнд хавсаргана.	Гэрээ байгуулагдснаас хойш ажлын 30 хоног



**Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчид хоорондын
харилцан холболтын орлого хуваарилах зарчим**

1. Үүрэн телефон холбооны үйлчлэгчийн сүлжээнээс бусад үүрэн болон суурин телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнд яриа төгсгөхөд харилцан холболтын орлого хуваарилах зарчим.

№	Үйлчилгээ эрхлэгч		Орлого хуваарилалт		
	Хаанаас	Хаашаа	Тариф	Яриа үүсгэгч талд	Яриа хүлээн авагч талд
1	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	xxx	(xxx-20 төг)	20 төг
2	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	xxx	(xxx-20 төг)	20 төг
3	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	xxx	(xxx-20 төг)	20 төг

2. Үүрэн телефон холбооны үйлчлэгчийн сүлжээнээс бусад үүрэн болон суурин телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнд мессеж төгсгөхөд харилцан холболтын орлого хуваарилах зарчим.

№	Үйлчилгээ эрхлэгч		Орлого хуваарилалт		
	Хаанаас	Хаашаа	Тариф	Мессеж илгээгч талд	Мессеж хүлээн авагч талд
1	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	xxx	(xxx-х/т)	Харилцан тохиролцсоноор (х/т)
2	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	xxx	(xxx-х/т)	Харилцан тохиролцсоноор (х/т)
3	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгч	xxx	(xxx-х/т)	Харилцан тохиролцсоноор (х/т)

3. Улс хоорондын гарах яриаг үүрэн телефон холбооны сүлжээнээс эхлүүлэх холболтын орлого хуваарилах зарчим

№	Улс хоорондын гарах яриаг үүрэн сүлжээнээс хэрэглэж буй хэрэглэгчийн 1 минутын төлбөр	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид үлдэх хэсэг	Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэгчид
1	ХТ = 50₮ + УХЯ төлбөр	50 төг	УХЯ төлбөр

Тайлбар:

- ХТ-Улс хоорондын гарах яриаг үүрэн сүлжээн дээрээс хэрэглэж буй хэрэглэгчийн төлж буй нийт төлбөр
- УХЯ төлбөр – Улс хоорондын гарах ярианы үйлчилгээний нэг минутын төлбөр
- 50₮ - Улс хоорондын гарах яриаг үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчийн сүлжээн дээрээс үүсгэхэд УХЯ-ны нэг минутын төлбөр бүр дээр хамт тооцогдох төлбөрийн хэмжээ, энэ төлбөрийг үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид өөртөө үлдээнэ.

Дээрх орлого хуваарилах зарчим нь Зохицуулах хорооны холбогдох тогтоол, тариф тогтоох аргачлал, зөвлөмжид үндэслэсэн болно.

**“МОБИКОМ КОРПОРАЦИ” ХХК БОЛОН “.....” ХХК-ИЙН
СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ**

20.. оны .. дугаар сарын ...-ний өдөр

№.

Улаанбаатар хот

Сүлжээ хоорондын харилцан холболтын энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомж, Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид ХХЗХ гэх)-ноос харилцан холболтын талаар баталсан журмууд, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д заасныг үндэслэн:

Нэг талаас: Мобиком Корпораци ХХК (цаашид “Мобиком” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал,

Нөгөө талаас: ХХК (цаашид “.....” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал (хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Талууд өөрийн сүлжээний хэрэглэгчдийн харилцаа холбооны хэрэгцээг хангах зорилгоор нөгөө талын сүлжээтэй харилцан холболт хийх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2 Талууд харилцан холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.3 Талууд ХХЗХ-ноос баталж гаргасан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам” болон харилцаа холбооны үйлчилгээнд мөрдөгдөх бусад холбогдох хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага, баримт бичгийг мөрдлөг болгон ажиллана.
- 1.4 Талууд дотоодын бусад компаниудын харилцан холболтын ачааллыг өөрийн сүлжээгээр дамжуулах (транзит хийх) нөхцөлд, тухайн компанийн нөгөө талтай байгуулсан харилцан холболтын гэрээг үндэслэл болгоно.
- 1.5 Гэрээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:
 - 1.5.1 Үндсэн хэсэг
 - 1.5.1.1 Ерөнхий зүйл;
 - 1.5.1.2 Талуудын эрх, үүрэг;
 - 1.5.1.3 Техникийн нөхцөл;
 - 1.5.1.4 Ашиглалт үйлчилгээ;
 - 1.5.1.5 Төлбөр тооцоо;
 - 1.5.1.6 Мэдээллийн нууцлал, хүний хувийн мэдээлэл;
 - 1.5.1.7 Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх;
 - 1.5.1.8 Хариуцлага;
 - 1.5.1.9 Маргаан шийдвэрлэх;
 - 1.5.1.10 Гэрээний үйлчлэх хугацаа;
 - 1.5.1.11 Гэрээг цуцлах, дуусгавар болгох
 - 1.5.1.12 Давагдашгүй хүчин зүйл;
 - 1.5.1.13 Бусад
 - 1.5.2 Хавсралт 1-1. Харилцан холболт хийх техникийн үзүүлэлтүүд, зааглах цэгийн байршил;
 - 1.5.3 Хавсралт 1-2. Харилцан холболтын төстийн хуудас, протокол;
 - 1.5.4 Хавсралт 2. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал;
 - 1.5.5 Хавсралт 3. Талуудын сүлжээний дугаарлалт;

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны нэмэлт: compliance@mobikom.mn

- 1.5.6 Хавсралт 4. Харилцан холболтын үйлчилгээний тариф, тооцоо нийлэх маягт;
- 1.5.7 Хавсралт 5. Мэдээлэл солилцох албан тушаалтан, тэдгээрийн нэрс, холбоо барих арга хэрэгсэл
- 1.6 Гэрээний хүрээнд талууд дор дурдсан харилцан холболтын үйлчилгээг үзүүлнэ:
 - 1.6.1 Дотоод дуудлага хийх;
 - 1.6.2 Дотоод дуудлага хүлээн авах;
 - 1.6.3 Өөрийн гарцаар улс хоорондын дуудлага гаргах;
 - 1.6.4 Өөрийн гарцаар улс хоорондын дуудлага оруулах.
 - 1.6.5 Дотоод мессеж илгээх;
 - 1.6.6 Дотоод мессеж хүлээн авах
- 1.7 Гэрээний хүрээнд талууд дор дурдсан транзит үйлчилгээг үзүүлнэ:
 - 1.7.1 Дотоодын орох дуудлага дамжуулах;
 - 1.7.2 Дотоодын гарах дуудлага дамжуулах;
 - 1.7.3 Улс хоорондын орох дуудлага дамжуулах;
 - 1.7.4 Улс хоорондын гарах дуудлага дамжуулах;
 - 1.7.5 Дотоод мессеж бичих;
 - 1.7.6 Дотоод мессеж хүлээж авах.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

- 2.1 Талууд дор дурдсан эрхийг эдэлнэ:
 - 2.1.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсвэл зохих ёсоор буюу шударгаар биелүүлэхийг нөгөө талаасаа шаардах;
 - 2.1.2 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах, гэрээнээс татгалзах, цуцлах, дуусгавар болгох тухай санал гаргах;
 - 2.1.3 Нөгөө тал буруутай нь тогтоогдвол өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах;
 - 2.1.4 Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд энэ гэрээний 8 дугаар зүйлд заасан хариуцлагын механизмыг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх;
 - 2.1.5 Үйлчилгээний төлбөр, алданги нэхэмжлэн авах;
 - 2.1.6 Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг шаардах;
 - 2.1.7 Шаардлагатай нөхцөлд холбогдох баримтуудыг гаргуулан авах;
 - 2.1.8 Энэхүү гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадвар, чадамжтай бөгөөд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нь Талуудын дүрэм, журам болон ижил төрлийн бусад баримт бичгийн нөхцөлтэй зөрчилдөхгүй, аливаа гуравдагч этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй болно;
 - 2.1.9 Гэрээний хэрэгжилтэд харилцан хяналт тавих, зөрчил дутагдлыг хугацаа тогтоон засахыг шаардах;
 - 2.1.10 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээг баримталж, нөгөө талынхаа хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэж, хамгаалахад хамтарч ажиллана.
- 2.2 Талууд дор дурдсан үүргийг хүлээнэ:
 - 2.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
 - 2.2.2 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр төлөх;
 - 2.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ нөгөө талынхаа бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх;
 - 2.2.4 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд учруулсан хохирлыг тогтоосон хугацаанд нь нөхөн төлөх;
 - 2.2.5 Гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх;
 - 2.2.6 Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх бол ХХЗХ-нд 72 цагийн өмнө, өөрийн сүлжээний хэрэглэгчид болон харилцан холбогч талд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: business@mobikom.mn

- 2.2.7 ХХЗХ болон салбарын эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, нөхцөл шаардлага, тогтоол шийдвэрийг чанд мөрдөж ажиллах;
- 2.2.8 Энэхүү гэрээний дагуу хүлээсэн бүхий л үүргээ хэрэгжүүлэх хангалттай ур чадвар, туршлага, хүний нөөцийн болон санхүүгийн чадвартай, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, үйл ажиллагаа явуулах эрхтэй ба уг зөвшөөрөл, эрх нь гэрээний хугацаанд хүчинтэй байна;
- 2.2.9 Энэхүү гэрээг байгуулагдах өдрийн байдлаар энэхүү гэрээтэй холбоотой талуудын амаар болон бичгээр өгсөн аливаа мэдээлэл, баримт нь үнэн зөв бүрэн байх;
- 2.2.10 Энэхүү гэрээнд дурдсан хориглосон үйл ажиллагааг явуулах, тэдгээрийг санхүүжүүлэх, ивээн тэтгэхийг нөгөө талаасаа шаардах, санал болгох, тулгах, гарцаагүй байдалд оруулах, шантаажлах зэрэг эдгээртэй адилтгах аливаа хэлбэрээр нөгөө талдаа зүй бус нөлөөлөл үзүүлэхгүй байх;
- 2.2.11 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх болон бусад бүхий л үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөн ажилладаг, ажиллах ба нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуун, ёс зүйн хэм хэмжээнд хар Төшилсөн, нөгөө талын нэр хүндэд харшлахуйц, үнэт зүйлд үл нийцсэн үйл ажиллагаа явуулахгүй байх;
- 2.2.12 Гэрээний нөгөө талын ажилтан, эрх бүхий этгээдэд ямарваа мөнгөн болон мөнгөн бус үнэ бүхий зүйл, давуу байдал санал болгоогүй, амлаагүй, олгоогүй ба хэлэлцээр хийх, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилттэй холбоотой шийдвэр гаргах явцад шударга бусаар нөлөөлөөгүй, авлигын эсрэг холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;
- 2.2.13 Аль нэг тал, түүний ажилтан, эрх бүхий этгээд нь Олон улсын болон Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг холбогдох хууль тогтоомжтой танилцсан, тэдгээрийг зөрчөөгүй, зөрчихгүй ба тэдгээрт нийцүүлэх үйл ажиллагаа явуулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

Гурав. Техникийн нөхцөл

- 3.1 Харилцан холболт хийх техникийн үзүүлэлт
 - 3.1.1 Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфэйсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байх ба өөрчлөлтүүдийг тухай бүр тусгана.
 - 3.1.2 Сүлжээ хоорондын дохиолол нь CCS7 байх ба цаашид өргөн зурвасын дохиоллын бусад протокол ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 3.1.3 Талуудын станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь 10^{-11} байна.
- 3.2 Зааглах цэг
 - 3.2.1 Сүлжээний зааглах цэгийн байршил Хавсралт 1-т заасны дагуу байна.
 - 3.2.2 Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.
 - 3.2.3 Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-т заасны дагуу байна.
 - 3.2.4 Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.
- 3.3 Сүлжээний ачаалал
 - 3.3.1 Талууд өөрсдийн холбох шугамын ачааллын хэмжээнд хяналт тавьж, шаардагдах зохицуулалтыг хийж ажиллана.
 - 3.3.2 Нэгж шугамд ногдох ачааллын хэмжээ 65%-аас хэтэрсэн тохиолдолд холбох шугамын тоог нэмэх асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны нэмэлт: 

- 3.3.3 Талуудын сүлжээнд хийгдэх өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талын сүлжээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг гурван сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.4 Дугаарлалт
 - 3.4.1 Талуудын сүлжээний дугаарлалт нь ХХЗХ-оос олгогдсон дугаарлалтын хүрээнд Хавсралт 3-д заасны дагуу байна.
 - 3.4.2 Аль нэг тал хууль тогтоомжийн хүрээнд сүлжээний дугаарлалт шинээр үүсгэх тохиолдолд талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж баталснаас хойш ажлын 5 /тав/ өдөрт багтаан нөгөө тал сүлжээндээ үүсгэнэ.
 - 3.4.3 Талууд нөгөө талын сүлжээнд яриа төгсгөхдөө дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулах үүрэгтэй. Энэ нь улс хооронд болон дотоодын ярианд ижил хамаарна.
 - 3.4.4 Талууд өөрт олгогдсон дугаарыг зориулалтын дагуу ашиглана.

Дөрөв. Ашиглалт үйлчилгээ

- 4.1 Зааглах цэгээс хоёр тийш талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, гэмтэл засвар, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 4.2 Талууд өөрийн сүлжээнд харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд аль болох ачаалал багатай өдөр, цагийг сонгох ба ажиллах хугацаа, горимыг хуанлийн 7 хоногийн өмнө албан бичиг болон цахим шуудангийн аль алинаар нь урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 4.3 Талууд харилцан холболтын ярианы өгөгдлүүд нь талуудын төлбөр тооцооны системд зөв ажиллаж байгаа талаар жил бүрийн эхний улиралд багтаан тест хийн баталгаажуулж протокол үйлдэж байна.
- 4.4 Аль нэг тал нь нөгөө талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан тал нь шуурхай арга хэмжээ авч, түргэн засварлах буюу нэн даруй нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлнө.
- 4.5 Талууд өөрсдийн сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэгтэй. Аль нэг талын буруутай үйлдэл, санамсар болгоомжгүй байдлаас, мөн техник технологи, мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг хангаагүйгээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах, хууль бус гэмт хэргийн шинжтэй халдлага, дайралт (fraud, attack) зэрэгт өртөх тохиолдолд тухайн тал нь нөгөө талд учирсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 4.6 Талууд өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гаднын халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас харилцан холболт хийсэн болон холбогдсон тохиолдолд дээрх шаардлагыг хангаагүй тал нь үүссэн хохирлыг хариуцна.
- 4.7 Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг Хавсралт 5-д заасан байна.
- 4.8 Талууд өөрийн сүлжээгээр дамжиж буй ачааллын урсгалд байнгын хяналт тавьж, хуурамч дуудлага (Spooft call), дугаар хуурамчаар өөрчлөх (CLI spoofing), дуудлагын шинж чанар, чиглэлийг төхөөрөмж ашиглан нуух, өөрчилөх (SIM Box), хэвийн бус урт хугацааны дуудлага (Long call alerting), урсгалын хэмжээний гэнэтийн өсөлт (Traffic volume assurance), хууль тогтоомж, зохицуулалтын нөхцөл шаардлагыг зөрчсөн бусад дуудлага, мессеж (Telemarketing, Spam messaging гэх зэрэг)-ийн урсгал, бусад хууль бус, залилангийн шинжтэй үйл ажиллагааг зөрчилтэй үйлдэл гэж үзэх бөгөөд түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлэн ажиллах ба ийм шинж чанартай дуудлага, мессежийг нөгөө талын сүлжээнд харилцан холболтын сувгаар дамжуулан төгсгөхгүй байна.
- 4.9 Талууд энэхүү гэрээний 4.8-д заасныг хэрэгжүүлээгүйгээс үүдэн зөрчилтэй дуудлага, мессеж нөгөө талын сүлжээнд илэрсэн гэж үзвэл зөрчил гаргасан хэрэглэгчийн дугаар, эсхүл дугааруудын хүрээнд нь өөрийн дотоод журамд заасны дагуу түр хязгаарлалт хийх, үйлчилгээг зогсоох болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцал хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: info@mobikom.mn

- 4.10 Энэхүү гэрээг үйлдэгдэхээс өмнө талуудын хийсэн харилцан холболтын тестийн үр дүн болон баталгаажуулсан протоколыг “Хавсралт 1,2”-ийн дагуу гэрээнд хавсаргасан байна.

Тав. Төлбөр тооцоо

- 5.1 Талууд 1 дүгээр зүйлийн 1.6-д заасан үйлчилгээнүүдийн харилцан холболтын төлбөрийг Хавсралт 4-т зааснаар сар бүр төлнө.
- 5.2 Талууд тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар харилцан туршилт хийж, баталгаажуулан протокол үйлдэж сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээнд хавсаргана. Талууд нэгэнт холбогдсон, гэрээний хугацааг сунгаж буй тохиолдолд энэхүү заалт хамаарахгүй.
- 5.3 Харилцан холболтын төлбөрийг хэрэглэгчээс нэхэмжлэхдээ тус тусын үйлчилгээний нөхцөлийг баримтлах бөгөөд харилцан холболтын төлбөрийг нэг секундний алхамтайгаар тооцно.
- 5.4 Талуудын төлбөр тооцоо хариуцсан ажилтнууд харилцан холболт хийгдсэн ачааллын өгөгдлийг тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн 8 хоногт багтаан электрон хэлбэрээр харилцан солилцож, хуанлийн 10 хоногт багтаан тооцоог Хавсралт 4-т заасан тариф болон тооцоо нийлэх маягтын дагуу цаасан дээр хийж баталгаажуулна.
- 5.5 Хэрэв талуудын ачааллын өгөгдлийн зөрүү нь аль бага талын өгөгдлийн +/-1%-иас хэтрээгүй бол талуудын өгөгдлийн дунджаар, аль бага талын өгөгдлийн +/-1%-иас хэтэрсэн нөхцөлд тухайн тайлант сарын тооцоог аль бага талын өгөгдлийн дүнгээр 5 дугаар зүйлийн 5.4-т заасан хугацаанд багтаан нийлж зөрүүг ажлын хэсэг байгуулан дараагийн тайлант сарын төлбөр тооцоо нийлэхээс өмнө тодорхойлж дараа сарын төлбөр тооцоонд тусгана.
- 5.6 Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь харилцан холболтын тооцоо нийлсэн өгөгдлийг үндэслэн харилцан холболтын төлбөрийн тооцоог 5 дугаар зүйлийн 5.4-т заасан хугацаанаас хойш ажлын 3 өдөрт багтаан нийлж илүү төлөлттэй талд нэхэмжлэхийг нэхэмжлэхийн дагуу төлбөр хариуцагч тал нь тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн 60 хоногийн дотор харилцан холболтын төлбөрийн зөрүүг түүнд ноогдох НӨАТ-ын хамт төлнө.
- 5.7 Талууд харилцан холболтын тооцоо нийлэх ачааллын өгөгдлийг нөгөө талдаа хүргүүлэхдээ сар сараар ээлжлэн харилцан өгнө.
- 5.8 Талууд харилцан холболтын ачааллын өгөгдлийн зөрүүг Хавсралт 4-т заасан үйлчилгээний чиглэл тус бүрээр тодорхойлно.
- 5.9 Талуудын ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 5.10 Талуудын сүлжээнд төгсөж байгаа ачаалал нь Хавсралт 3-т дурдсанаас өөр дугаарлалтаар төгссөн тохиолдолд талуудын холбох шугамаар орж ирсэн бүх ачааллыг талуудын үүсгэсэн ачаалал гэж тооцон харилцан холболтын төлбөрийн тооцоог нийлнэ.
- 5.11 Талууд нь тухайн сард харилцан төлөх нийт төлбөрийн 5%-ийг тус тусын талд орлого цуглуулах шимтгэлд тооцож үлдээнэ.
- 5.12 Аль нэг тал өөрийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах бол тайлант сар эхлэхээс ажлын 10 өдрийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.13 Гэрээний 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу илүү төлөлттэй талдаа харилцан холболтын төлбөрийн нэхэмжлэхийг тухайн цаг хугацаанд өгөөгүй нь төлбөрийг шаардах эрхийг дуусгавар болгох үндэслэл болохгүй.
- 5.14 Энэхүү гэрээнд заасан зөрчилтэй үйлдлийн улмаас арга хэмжээ авсан нь харилцан холболтын төлбөр төлөх болон бусад хариуцлагаас чөлөөлөхгүй.

Зургаа. Мэдээллийн нууцлал, хүний хувийн мэдээлэл

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: compliance@mobikom.mn

- 6.1 Талууд гэрээ байгуулах болон хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан нөгөө талын бизнесийн болон хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (дотоод зохион байгуулалт, техникийн шийдэл, хамгаалалт, аюулгүй байдал гэх мэт)-ыг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхол, эсвэл түүний эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар, бичгээр, болон аливаа бусад хэлбэрээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 6.2 Талууд энэхүү гэрээг байгуулах, ашиглах, хоорондоо дамжуулах бол мэдээллийн эзнээс нь зөвшөөрөл авах, холбогдох хуулийн нийцлийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд ийнхүү хангаагүйгээс үүсэх аливаа эрсдэлийг өөрөө бүрэн хариуцна.
- 6.3 Гэрээний 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-д заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд буруутай тал түүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.
- 6.4 Гагцхүү төрийн эрх бүхий байгууллага хуульд заасан үндэслэл журмын дагуу шаардсанаар 6 дугаар зүйлд заасан мэдээллийг олгож болно.

Долоо. Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх

- 7.1 Талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын төлбөр, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаарх бизнесийн нууц бус мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор хүссэн талд гаргаж өгнө. Талууд бусдаас авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.
- 7.2 Талууд өөрийн сүлжээнд холбогдох боломжийг тухай бүрд нь аль болох шуурхай бүрдүүлж өгнө. Тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд хэдийд уг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой тухайгаа хариу мэдэгдэнэ.
- 7.3 Талууд өөрийн сүлжээний дугаарлалтад өөрчлөлт оруулах, нөгөө талын сүлжээнд шинэ чиглэл үүсгүүлэх, чиглэл өөрчлүүлэх, хаах, холбох шугамын тоог нэмэх тухай асуудлыг нөгөө талдаа тухай бүр ажлын 10 өдрийн өмнө мэдэгдэх ба хүлээж авсан тал ажлын цар хэмжээнээс хамааран гүйцэтгэх хугацааг тохирон хэрэгжүүлнэ. Жич: Тухайн дугаарын өөрчлөлт нь харилцан холболтын төлбөр тооцоотой холбоотой бол талууд энэ талаар харилцан тохиролцсоны дараа хэрэгжүүлнэ.
- 7.4 Талууд мэдээллээ албан бичгээр харилцан солилцоно.

Найм. Хариуцлага

- 8.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх эсхүл зөрчсөн тохиолдолд энэ гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх бөгөөд нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.2 Аль нэг тал энэ гэрээтэй холбоотойгоор нөгөө талын бизнесийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг нөгөө талын өмнө бүрэн хариуцна.
- 8.3 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл удаа дараа зохих ёсоор биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг хангах доор дурдсан аргыг шат дараатайгаар эсвэл шууд хэрэглэх эрхтэй байна. Үүнд:
 - 8.3.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлэх;
 - 8.3.2 Гэрээний 8 дүгээр зүйлийн 8.4-т заасан нөхцөлийн дагуу алданги тооцох;
- 8.4 Алдангийг дор дурдсан нөхцөлд тооцно. Үүнд:
 - 8.4.1 Аль нэг тал 5 дугаар зүйлийн 5.6-д заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн бол;
 - 8.4.2 Аль нэг талын аливаа алдаа эсвэл буруутай үйлдлээс шалтгаалж харилцан холболтын тооцоог 5 дугаар зүйлийн 5.4-т заасан хугацаанд багтаан нийлээгүйн улмаас 5 дугаар зүйлийн 5.6-д заасан төлбөр төлөх хугацаа хойшилсон бол;
 - 8.4.3 Аль нэг тал энэ гэрээ болон хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцан холболтын тооцоог нийлээгүй, нийлэхийг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас 5 дугаар зүйлийн 5.6-д заасан хугацаа өнгөрсөн бол.
- 8.5 Алданги нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.3 хувь байна.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: business@mobikom.mn

- 8.6 Гэрээний 8 дугаар зүйлийн 8.3-т заасан арга хэмжээг хүлээсэн нь талуудыг гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхгүй байх болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх хууль зүйн үндэслэл болохгүй.
- 8.7 Учирсан хохирол гэдэгт аль нэг талаас гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талаас гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, гэм буруутай тал гэрээнд заасан үүргээ гүйцэтгэсэн бол нөгөө талд учрахгүй байсан зарлага зэрэг бодит хохирлыг тооцно.

Ес. Маргаан шийдвэрлэх

- 9.1 Гэрээтэй холбогдон үүсэж болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 9.2 ХХЗХ-ноос гаргасан шийдвэрийг маргалдагч талууд аль болох хүлээж авна. Хэрэв ХХЗХ-ны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй эсвэл ХХЗХ хуульд заасан хугацаанд шалгаж хариу өгөөгүй бол талууд шүүхэд хандах эрхтэй.

Арав. Гэрээний үйлчлэх хугацаа

- 10.1 Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар гэрээ 20.. оны .. дугаар сарын ..-ний өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 10.2 Гэрээний хугацаа дуусахаас хуанлийн 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах, шинэчлэх санал гаргаагүй тохиолдолд гэрээ нь цаашид ижил нөхцөлөөр нэг жилийн хугацаатай сунгагдсанд тооцно.
- 10.3 Талууд 12-р зүйлд заасны дагуу энэхүү гэрээг цуцалж болох ба гэрээнд заасан нөхцөлөөс бусад тохиолдолд гэрээг аль нэг тал дангаараа цуцлахыг хориглоно. Талуудын аль нэг нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухай хүсэлтээ нөгөө талдаа 2 сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 10.4 Гэрээний хугацаа дуусгавар болсноор мөн гэрээ цуцлагдсанаар гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой шаардах эрхээс бусад талуудад олгогдсон эрх, үүрэг мөн адил дуусгавар болно.

Арван нэг. Харилцан холболтыг хязгаарлах, түр салгах

- 11.1 Энэхүү гэрээгээр хийгдсэн сүлжээний харилцан холболтыг дараах тохиолдолд хязгаарлах болон түр салгаж болох ба энэ нөхцөлд 2.2.6-д заасныг баримтлана.
- 11.1.1 Аль нэг тал энэхүү гэрээний 4.8-д заасныг хэрэгжүүлээгүйгээс үүдэн 4.9-т заасан арга хэмжээ авсан ч 4.8-д заасан зөрчил үргэлжилсээр байх тохиолдолд нөгөө тал зөрчилтэй дугааруудад хязгаарлалт хийнэ.
- 11.1.2 Аль нэг тал 11.1.1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш хуанлийн 14 хоногийн хугацаанд зөрчлийг арилгах талаар зохих арга хэмжээ аваагүй, эсхүл зөрчил үргэлжлэн давтагдсан тохиолдолд зөрчилтэй үйлчилгээ, маршрут, холболтын суваг, харилцан холболтын урсгалд хязгаарлалт тогтооно.
- 11.2 Энэхүү гэрээний 11.1.2-т заасан хязгаарлалтын арга хэмжээг авсан боловч тухайн зөрчил давтагдсаар байгаа тохиолдолд болон дараах тохиолдолд түр салгалт хийнэ. Үүнд;
- 11.2.1 Гэрээгээр тохиролцсон техникийн үзлэг, шалгалт хийхэд шаардлага хангаагүй бөгөөд уг зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй;
- 11.2.2 Харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бөгөөд төлбөрийн хугацааг 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд;
- 11.2.3 Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон.

Арван хоёр. Харилцан холболтыг салгах, дуусгавар болгох

- 12.1 Дараах тохиолдолд Талууд нь гэрээг энэхүү гэрээний 2.2.6 заалтын дагуу дангаар харилцан холболтыг салгах, дуусгавар болгох эрхтэй.
- 12.1.1 Эрх бүхий байгууллагын шийдвэрээр харилцан холболтын дагуу үзүүлж буй үндсэн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, цуцалсан;

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны нэмэлт: [mobikom@mobikom.mn](#)

- 12.1.2 Харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөхгүй 3 сараар хэтрүүлж 8 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэж эхэлснээс хойш нөгөө тал хуанлийн 30/гуч/ хоногийн дотор төлбөрөө төлөөгүй;
- 12.1.3 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гарсан журам, холбогдох нөхцөл шаардлагыг зөрчсөн бөгөөд уг зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй талаар эрх бүхий байгууллагаас мэдэгдэл ирсэн;
- 12.1.4 Аль нэг тал энэхүү гэрээний 3.4.4-д заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөн бөгөөд уг зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй нь тогтоогдсон;
- 12.1.5 Гэрээний хугацаа дууссан бөгөөд талууд Гэрээний хугацааг сунгахгүй байхаар харилцан тохиролцсон;
- 12.1.6 Талууд харилцан тохиролцож эсхүл гэрээнд заасны дагуу аль нэг талын санаачилгаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан;
- 12.1.7 Аль нэг талын харилцан холболтын дагуу үзүүлж буй үндсэн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл дуусгавар болсон эсвэл хүчингүй болсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;
- 12.1.8 Аль нэг тал төлбөрийн чадамжгүй болсон нь нийтэд тодорхой болсон, эсхүл эрх бүхий байгууллагаас энэ тухай мэдэгдсэн;
- 12.1.9 Цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон болон дампуурснаа албан ёсоор зарласан.

Арван гурав. Давагдашгүй хүчин зүйл

- 13.1 Давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 13.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 3 өдрийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 13.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 13.4 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригиос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 13.5 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

Арван дөрөв. Бусад

- 14.1 Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 14.2 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 14.3 Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 өдрийн дотор гэрээг хавсралтуудын хамт ХХЗХ-д хүргүүлнэ. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг тухай бүр ХХЗХ-нд тухай бүр хүргүүлж байна.
- 14.4 Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор талуудын хооронд 20.. оны ..-р сарын ..-ны өдөр байгуулсан тоот “Сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээ” болон түүний нэмэлт гэрээнүүдийг дуусгавар болсонд тооцно.
- 14.5 Гэрээний 14 дугаар зүйлийн 14.4-т заасны дагуу өмнөх гэрээг цуцалсан нь уг гэрээний төлбөрийн шаардлага гаргах эрхийг хөндөхгүй буюу дуусгавар болгохгүй.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: compliance@mobikom.mn

- 14.6 Талуудын хувь нийлүүлэгчид, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хувьцааны өмчлөл зэрэг өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран 10 дугаар зүйлийн 10.1, 10.2-т заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

Талуудын албан ёсны хаяг, бусад өгөгдлүүд:

Мобиком Корпораци ХХК:

..... ХХК:

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

ЮНЕСКО-ийн гудамж-28,

Ш/х-38, УБ 15171

Бүртгэлийн гэрчилгээ: 9019005111

Регистрийн дугаар: 2072572

Утас : 75759944-5004

Факс: 310411

Гэрээ байгуулсан:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

**Мобиком Корпораци ХХК-ийг
төлөөлж:**

..... ХХК-ийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: compliance@mobikom.mn

ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Мобиком	
Холболтын байгууламжийн төрөл, марк		
Дамжуулах /нягтруулах төхөөрөмж/ байгууламжийн төрөл, марк		
Холбох шугамын төрөл, марк, багтаамж		
Интерфейсийн төрөл		

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Зааглах цэг	Байршил
Зааглах цэгийн байршил	
Тоног төхөөрөмж	

Хавсралт баталсан:

Мобиком Корпораци ХХК-ийг
төлөөлж:

..... ХХК-ийг төлөөлж:

.....

Гүйцэтгэх захирал

.....

Гүйцэтгэх захирал

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: info@mobikom.mn

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ТЕСТИЙН ХУУДАС, ПРОТОКОЛ

Талуудын жийх харилцан холболтын тестийн хуудас

[illegible]

Сүлжээ хоорондын харилцан холболтын тест хийсэн тухай протокол
Огноо: Улаанбаатар хот

Мобиком ХХК болон ХХК-ийн хооронд байгуулсан сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээний хүрээнд харилцан холболтын тестийг дараах байдлаар харилцан хийв.

Тест хийсэн өдөр:

Хамрах хүрээ:-с Мобикомын сүлжээнд төгссөн, Мобиком-с сүлжээнд төгссөн тест дуудлага болон мессежний Мобиком болон талын бичлэгүүдийг тулгасан

1. Холболтын байгууламж TDM холболттой бол: Мобикомынpoint code,-ны point code
2. SIP холболттой бол төхөөрөмж IP хаяг: Мобиком-,-
3. Хоёр талын ярианы бичлэгүүдийн эхлэх хугацааны зөрүү болон нэг ярианы үргэлжлэх хугацааны зөрүү нь секунд дотор
4. Хоёр талын нэг мессежний тэмдэгтийн хязгаар нь

Протоколыг үйлдсэн:

Мобиком Корпораци ХХК-ийг төлөөлж:

..... ХХК -ийг төлөөлж:

Нэр:
Албан тушаал:
Утас:
И-мэйл:

Нэр:
Албан тушаал:
Утас:
И-мэйл:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: business@mobikom.mn

ТАЛУУДЫН СҮЛЖЭЭНИЙ ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

Хавсралт баталсан:

**Мобиком Корпораци ХХК-ийг
төлөөлж:**

..... ХХК-ийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: compliance@mobikom.mn

ТАЛУУДЫН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

МОБИКОМЫН ТЕЛЕФОН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Үйлчилгээ	Дугаарлалт
Үүрэн холбоо	

.....ГИЙН ТЕЛЕФОН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Үйлчилгээ	Дугаарлалт
Үүрэн холбоо	

Хавсралт баталсан:

Мобиком Корпораци ХХК-ийг
төлөөлж:

.....-ийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: info@mobikom.mn

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ

Дотоод урьдны харилцан холболтын үйлчилгээ

Чиглэл		Хяналас	Хяаншаа	Тариф	Мобиком-д	-д
Төгсөл	Төгсгөл					

Улс хоорондын урьдны харилцан холболтын үйлчилгээ

Чиглэл		Хяналас	Хяаншаа	Тариф	Мобиком-д	-д
Төгсөл	Төгсгөл					

- .. - Мобикомын тухайн үйлчилгээний тариф;
 .. - Мобикомын ОУ-н дуудлага хүлээн авах тариф;
 .. - Мобикомын улс хоорондын ... гарцын тариф;

Хавсралт баталсан

Мобиком Корпораци ХХК-ийг
төлөөлж:

..... ХХК-ийг төлөөлж:

.....

Гүйцэтгэх захирал

.....

Гүйцэтгэх захирал

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: businessconduct@mobikom.mn

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ТООЦОО НИЙЛЭХ МАЯГТ

[illegible]

Материал, № п/п	сорт	масса	сорт (масса)	Темп
Яриа				

Тооцоо нийлсэн

Мобикомыг төлөөлж: _____ инженер
.....-г төлөөлж: _____ инженер

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны нийлэл:

**ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН,
ТЭДГЭЭРИЙН НЭРС, ХОЛБОО БАРИХ АРГА ХЭРЭГСЭЛ***Мобиком Корпорацийн албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл:*

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			
Техникийн асуудлаар			
Төлбөр тооцооны асуудлаар			

.....-ны албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл:

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			
Техникийн асуудлаар			
Төлбөр тооцооны асуудлаар			

Хавсралт баталсан:

**Мобиком Корпораци ХХК-ийг
төлөөлж:****..... ХХК-ийг төлөөлж:**

.....

Гүйцэтгэх захирал

.....

Гүйцэтгэх захирал

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Бид Монгол улсын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөн, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэнэ. Энэ гэрээ болон Мобиком Групптэй хамтран ажиллаж байгаа бизнесийн харилцааны хүрээнд та манай ажилтны ёс зүйн талаар мэдээлэл өгөхийг хүсвэл дараах хаягаар хандана уу. Байгууллагын ёс зүйн хорооны имэйл: info@mobikom.mn